

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн ээлжит хуралдаан 2014 оны 6 дугаар сарын 23-ны өдөр хуралдлаа. Хуралдаанаар: (i) ББСБ-уудыг Монголбанкны гадаад валютын дуудлага худалдаанд оролцуулах, гадаад валютын своп, форвард хэлцэл байгуулах болон Монголбанкны үнэт цаас худалдан авах, бичил санхүүгийн зээлийг дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагаанд хамруулах боломжийн тухай (СЗХ); (ii) Монгол Улсын зээлжих зэрэглэл, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийн шинжилгээ (Монголбанк); (iii) Монгол Улсын гадаад секторын болон гадаад валютын дотоодын захын тойм (Монголбанк); (iv) Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн шийдвэрийн тухай зэрэг асуудлыг авч хэлэлцлээ (Монголбанк).

Хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс холбогдох газруудад хариуцсан чиглэлээр тодорхой үүрэг даалгавар өгсөн болно.

СТБЗ-ИЙН АЖЛЫН АЛБА